

Батлав:

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО

ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

_____ / Б.БУЯННЭМЭХ /

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

“ФЕН ШУ ЗУН” ХХК-ийн ЗАХИРАЛ

_____ / DONG XIAO ZHONG /

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ
НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Регистрийн дугаар: 6322824

Хянасан:

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН

Мэргэжилтэн _____ / Н.Жаргалнэмэх /

Боловсруулсан:

“Фен Шу Зун” ХХК-ийн

Байгаль орчны мэргэжилтэн _____ / Д.Номинцацрал /

1. ТӨСЛИЙН ТАЛААР ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл


Төслийн нэр:	Нүүрс баяжуулах үйлдвэр төсөл
Төсөл хэрэгжүүлэгч:	Хувийн хөрөнгө оруулалттай “Фен Шу Зун” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9019088116, Регистрийн дугаар: 6322824, Газар эзэмших гэрчилгээний дугаар : 000344802
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	УБ хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо Утас: 99118988
Төслийн байршил:	Дорноговь аймаг, Даланжаргалан сум, Олон-Овоо баг, Сайншанд хотоос 140 км-т байрлана.

“Фен Шу Зун” ХХК-ийн Нүүрс баяжуулах үйлдвэр нь Чойр хотоос зүүн урагш 55 км, Сайншанд хотоос баруун хойш 140 км, төмөр замаас 1 км зайд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын төвөөс 17 км-ийн зайд 5.86 га талбай бүхий үйлдвэрийн зориулалттай талбайд хэрэгжинэ.

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлын цэгүүд

№	Уртраг	Өргөрөг
1	108°56'5.0	45°56'59.0
2	108°56'7.0	45°57'5.0
3	108°56'22.0	45°57'6.0
4	108°56'20.0	45°57'0.0

Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг



Зураг 2. Төсөл хэрэгжих талбайн зураг



1.2 Төслийн үйл ажиллагаа, хүчин чадал

"Фен Шу Зун" ХХК нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Баруун далан, Алаг толгод нүүрсний ордыг түшиглэн жилдээ 1000 мян.тн нүүрс угаан баяжуулах хүчин чадалтай үйлдвэр барьж, Монгол Улсын хууль, дүрэм журмын хүрээнд эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд хор хөнөөл бага үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж, улмаар улс, орон нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортын бүтээгдэхүүний хэмжээ болон түүнээс орох орлогыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн дэвшилтэт техник технологи, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шинэ дүрэм журам нэвтрүүлэх, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангах, баяжуулах үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлтийг бүрэн хийх, орон нутагт хүлээлгэн өгөх зэрэгт төслийн зорилго оршиж байна.

Төсөл хэрэгжүүлэгч нь жилд 1000 мян.тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай 10 жил ажиллах үйлдвэрийг барьж байгуулахаар төлөвлөөд байна. Нүүрс баяжуулах үйлдвэр нь тасралтгүйгээр долоо хоногийн 7 өдөр 10 цагаар 2 ээлжээр ажиллах ба тус үйлдвэрийн жилд ажиллах боломжит хугацаа нь 8040 цаг бөгөөд жилд ажиллах төлөвлөгөөт цаг 7236 цаг байхаар тооцсон байна.

Хүснэгт 2. Үйлдвэрийн ажиллах горим, үндсэн үзүүлэлтүүд


№	Үзүүлэлтүүд	Утга
1	Жилийн хуанлийн өдрийн тоо	365
2	Жилийн хуанлийн сар	12

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт байрлах Нүүрс баяжуулах үйлдвэр байгуулах төслийн
2023 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

3	Жилийн хуанлийн цаг	8760
4	Өдрийн хуанлийн цаг	24
5	Жилийн баяр ёслолын өдөр	11
6	Жилийн төлөвлөгөөт засвар үйлчилгээний хоног	14
7	Жилийн төлөвлөгөөт бус засвар үйлчилгээний хоног	7
8	Өдөрт ажиллах боломжит цаг	24
9	Жилд ажиллах боломжит хоног	335
10	Жилд ажиллах боломжит цаг	8040
11	Үйлдвэрийн цаг ашиглалт %	90
12	Техникийн бэлэн байдлын коэффициент %	90
13	Жилд ажиллах бодит цаг	7236
14	Цагийн хүчин чадал, тн/цаг	153.5
15	Хоногийн хүчин чадал, тн/хоног	5527.9
16	Жилийн хүчин чадал, тн/жил	1000000

Тус төсөлд хөдөлмөрийн зохион байгуулалтын хувьд 4 үндсэн хэсэгт хуваагдана. Захиргаа, аж ахуй, засвар механикийн хэсгийн ажилчид хоногт 8 цагийн 1 ээлжээр ажиллана. Нүүрс баяжуулах үйлдвэрийн хувьд хоногт 10 цагийн 2 ээлжээр тасралтгүй ажиллана. Тус хэсгүүдийн ажилчид үйлдвэр дээр 14 хоног ажиллаж 7 хоног амрах буюу ажлын 3 ээлжтэй байна. Үйлдвэрийн дарга, ерөнхий инженер 1 орон тоотой ажилтан амрах хугацаанд түүнийг орлогч, технологич инженер зэрэг ажилтнууд орлох үүрэгтэй байхаар төлөвлөжээ. Үйлдвэрийн удирдлага зохион байгуулалтын бүтцийн дагуу нийт 85 ажилтны орон тоотой байна. Үүнээс удирдах хэлтэст 9, техник технологийн хэлтэст 35, засвар механикийн хэлтэст 25, туслах ажилчин 8, ХАБЭА хэсэгт 4 хүн тус тус байна.

Зураг 1. Төслийн ажиллах хүсний мэдээлэл



1.3 Төслийн технологи, тоног төхөөрөмжийн жагсаалт

Нүүрсийг баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийг сонгохдоо нүүрс баяжуулахад өргөн хэрэглэгддэг технологи болох тунаах машинаар баяжуулах нь үйлдвэрийн зай талбай бага, эдийн засагт хэмнэлттэй, сайн чанарын нүүрс гарган авах давуу талуудыг харгалзан үзэж, БНХАУ-ын Shanxisheng Jiexiuxhi Lida Jixiexhizaoy ХХКомпанийн тоног төхөөрөмжийг суурилуулахаар төсөлд тусгасан байна.

Хүснэгт 3. Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Тоног төхөөрөмжийн нэрс	Марк	Тоо хэмжээ	Суурьлагдсан чадал (кВ)	Нийт хүчин чадал (кВ)
1	Чичиргээт шигшүүр	1530	2	7.5	15
2	Чичиргээт гэжээгүүр	ZD0815	2	3x2	12
3	Туузан конвейер	B=1000	1	5.5	5.5
4	Булт бутлуур	2PG1000	1	30	30
5	Чичиргээт гэжээгүүр	ZD1517	1	3	3
6	Тунаах машин	XKT-16-3	1	4X3	12
7	Усгүйжүүлэх элеватор	B3280	1	7.5	7.5
8	Нуман шигшүүр	B3260	2	7.5	15
9	Центрифуг	ZK2448	2	3	6
10	Шламын шигшүүр	TLL-1150	1	110	110
11	Компрессор	ZKS1843	6	5.5x2	66
12	Өтгөршүүлэгч	Φ=3.0	1	11	11
13	Агааржуулагч	NG-15	1	18.5	18.5
14	Даралтат шүүлтүүр	Φ=1200	1	4	4
15	Компрессор	Φ=1500	1	4	4
16	Компрессор	GZMZ400	2	12	24
17	Вентлятор	Q=m ³ P=0.8MPa		22	22
18	Эргэлтийн усны насос	Q=16m ³		90	90
19	Булингийн насос	Q=160m ³		160	160
20	Даралт шүүлтүүрийн насос	Q>750		110	110
21	Бохир усны насос	Q>750		132	132
22	Үзлэг засварын кран	ZJ100-42		90	90
23	Туузан конвейр	Q>80		11	11
24	Туузан конвейр	5T		7.5	7.5
25	Туузан конвейр	B=1000		37	37
26	Туузан конвейр	B=1000		5.5	5.5
27	Туузан конвейр	B=1000		37	37
28	Туузан конвейр	B=800		7.5	7.5
29	Туузан конвейр	B=1000		7.5	7.5
30	Туузан конвейр	B=1000		30	30


1.4 Төслийн төлөвлөлт, дэд бүтэц

Нүүрс баяжуулах үйлдвэр нь ил уурхайгаас жилд олборлосон 1000 мян.тонн нүүрсийг хүлээн авч баяжуулах хүчин чадалтай байх бөгөөд баяжуулах үйлдвэр нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Үүнд:

- Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилга, түүн дотор усгүйжүүлэх хэсэг, тунаах машин, нуман шигшүүр, шламгүйжүүлэх шигшүүр, конвейер, усгүйжүүлэх шигшүүр, центрифуга болно.
- Цэвэр нүүрсний нөөцийн талбай, түүхий нүүрсний нөөцийн талбай;
- Үйлдвэрлэлийн талбайд байрлах засварын газар, албан контор болон тээврийн хэрэгслийн зогсоолууд орно.

Зураг 2. Төлөвлөлтийн зураг



1.5 Төслийн түүхий эд, туслах материал

Баруун Далангийн ордын нүүрсэнд эрчим хүчний түүхий эд болох талаас нь чанарын судалгаа хийсэн байдаг. Авсан бүх дээжийнд үнс, чийг, дэгдэмхий бодисын агуулгыг тодорхойлсон. Зарим нэг дээжийг түүвэрлэсэн хүхэр, фосфорын агуулгыг тодорхойлж дулаан ялгаруулах чанарын судалгаа хийсэн. Мөн зарим дээжийн үнсэнд химийн болон гэрлийн шинжилгээ хийсэн байна.

Нүүрсний техникийн шинжилгээ

Алагтолгод нүүрсний ордод 2013 онд өрөмдсөн нийт 10 цооногийн 6 нь нүүрсний давхарга огтолсон бөгөөд эдгээр цооногуудаас авсан дээжинд хийсэн шинжилгээний үр дүнгээр ордын анхдагч нүүрсний нийт чийг 10.24%, чөлөөт чийг 6.8% байна.

- *Агаарын хуурай нөхцөл дэх:* чийг 3.72, үнсжилт 32.6%, дэгдэмхий бодисын гарц 14.33%, чөлөөт нүүрстөрөгчийн агуулга 49.33%, дулаан ялгаруулах чадвар 5032 ккал/кг, нийт хүхэр 0.94% байна.
- *Хуурай нөхцөл дэх:* үнсжилт 33.8%, дэгдэмхий бодисын гарц 15.05%, чөлөөт нүүрстөрөгчийн агуулга 51,13%, дулаан ялгаруулах чадвар 5213 ккал/кг, нийт хүхэр 0.98% байна.

- *Үнсгүй хуурай нөхцөлд*: дэгдэмхий бодис 22.37%, дулаан ялгаруулах чадвар 6293 ккал/кг байна. Чанарын үүүлэлтээс үзэхэд нүүрсний хөөний үнслэг 59.10%, исэлдсэн нүүрсний 42.18%, цэвэр нүүрсний үнслэг 32.60%-тай байна. Үнсжилт болон бусад үзүүлэлтийг харгалзан чанараар нь хуваалаа.

Алагтолгод-1 талбайн нүүрсний чанарын хувьд бусад хэсгүүдээс бага зэргийн өөрчлөлттэй байгаа нь хайгуулын талбайд огтлогдсон нүүрс нь Цэрдийн цагаанцав формацын бялхмал чулуулгаар хучигдсан байдагтай нүүрсний чанар өөрчлөгдсөн байдаг.

Шинжилгээний үр дүнгээс харахад Алагтолгод ордын нүүрс нь витринитийн гэрлийн ойлгох чадвар-0.6%, дэгдэмхий бодисын гарц-15.1-39.1 хуурай нөхцөлд интеринитийн агуулга-3% байгаа нь БНМАУ-ын ангилалаар чулуун нүүрсний Ч12 маркийн урт дөлтөөс бөсөх (ЧЗ), (MNS6456:2014) маркийн ангилалд хамаарагдахаар байна. Ийм чанарын нүүрсийг эрчим хүчний чиглэлээр байнгын ажиллагаатай цахилгаан станц, галладаг уурын зуух, галт тэрэг, ахуйн хэрэглээний галлагаанд ашиглах боломжтой.

Барилга байгууламж

Барилгын нийт урт 37.6 м, өргөн нь 45.5 м, өндөр нь 18 м болон 3 м байна. Баяжуулах үйлдвэрийн захиргаатай нэг байранд байхаар төлөвлөсөн.

- Үйлдвэрийн гол тоног төхөөрөмжүүд байрлана.
- Өтгөрүүлэх төхөөрөмж байрлана.

Засвар үйлчилгээний хэсэг

Засвар үйлчилгээний хэсэгт баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдэд төлөвлөгөөний дагуу ээлжит засвар үйлчилгээ хийхийн зэрэгцээ шинээр тоног төхөөрөмж угсрах, аваарын үед шаардлагатай засвар үйлчилгээ гүйцэтгэнэ. Засвар үйлчилгээний хэсэг нь өргөх кранаар хангагдсан байна. Механик, цахилгааны төхөөрөмжийн засварын хэсэг болон өргөн хэрэглээний засварын 2 албатайгаар зохион байгуулна. Эдгээр өрөөний шал нь бетон цутгамал байхаар төлөвлөсөн.


Бүтээгдэхүүний агуулах, ачих төхөөрөмж

Том бүхэллэгтэй болон нунтаг эрчим хүчний зориулалттай нүүрсийг нийлүүлж холих бөгөөд баяжуулах үйлдвэрийн конвейер нь цементэлж бэлдсэн баяжмалын ил агуулахын төвд хүрэхээр тоноглогдоно. Нүүрсийг конвейероор тээвэрлэн тусад нь бэлдсэн талбайд буулгаж, дугуйт ачигчаар авто тээврийн хэрэгсэлд ачиж, пүүлж гаргана. Баяжуулах үйлдвэрийн бэлэн бүтээгдэхүүний агуулахууд нь ил талбайд овоолго үүсгэж хадгалагдах бөгөөд байгаль орчинд үүсэх тоосжилтоос сэргийлэх үүднээс өндөр угсардаг төмөр хашаагаар хүрээлэгдсэн байхаар төлөвлөсөн байна.

Зураг 3. Баяжуулах үйлдвэрийн зураг



Зураг 4. Нүүрс буулгалтын хэсэг



Гал илрүүлэх систем

Нүүрс баяжуулах үйлдвэр хуваарилах байгууламж бүрт гал илрүүлэгч систем суурилуулах ба үүнд утааг нэн эрт илрүүлэх аппарат багтана (гал илрүүлэх систем нь кабелийн бүс, программчлагдах логик контроллерын хэсгүүд, бие даасан USB-үүд, оруулгын хэсэгт байрлана).

- Ойрын талбай дахь үйлдвэрийн албан хаагчдад мэдэгдэхийн тулд дотоод дохиоллыг ашиглана
- Хөдөлгүүрийн оруулгыг таслана
- Хяналтын систем болон галын хяналтын системд дохио өгнө.

Гэрэлтүүлэг

Гэрэлтүүлгийн түвшин нь доор үзүүлсэнчлэн зохих стандартын шаардлагад нийцсэн байна.

Гэрэлтүүлгийн зураг төслийг тооцоолохдоо доорх хүчин зүйлийг харгалзан үзнэ. Үүнд:

- Засвар, цэвэрлэгээний цикл нь 2 сар байна.
- Чийдэнгийн насжилт 1000 цаг байна.

Талбайг ерөнхийд нь гэрэлтүүлэхэд өргөн гэрэлтүүлгийг, зэргэлдээх зүйлсийн хувьд бол чиглэсэн гэрэлтүүлгийг ашиглана. Талбайн хэмжээ, зам, овоологч машины гэрэлтүүлгийг харгалзаж овоолгын гэрэлтүүлгийг хянана. Ажилчид зөөвөрлөх зам дээгүүр аюулгүй зорчих боломжийг олгох үүднээс өргөгдсөн зам дээгүүр зөөвөрлөгчийн гэрэлтүүлгийг тусгана. Нүүрс баяжуулах үйлдвэрийн дотоод засал нь булангийн өндөр гэрэл буюу хаалганы дээрх гэрэлтэй зохицсон байна. Зөөврийн гэрлээр аваарын гэрэлтүүлгийг хийнэ. Байгууламж доторх гарцын шугамын харагдац, чиглэлийн өөрчлөлт зэргийг аваарын гэрлээр гэрэлтүүлнэ. НБҮ-ийн гэрлийн шилжүүлгийг хяналтын системээр дамжуулан гүйцэтгэнэ.

Технологийн хаягдал

Нүүрс баяжуулах үйлдвэрийн технологиос хатуу ба шингэн хаягдал гарна. Хатуу хаягдлыг шууд хаягдал цуглуулах конвейер дээр цуглуулана. Харин шингэн хаягдлыг өтгөрүүлэгчээр дамжуулан даралтад шүүлтүүрээр усгүйжүүлэн мөн хаягдал цуглуулах конвейер дээр бууна. Энэ хаягдал цуглуулах конвейер нь хаягдал хадгалах талбайд буулгана.

Цахилгаан хангамж

Төсөлд шаардлагатай эрчим хүчийг төслийн талбайгаас баруун хойд талд байрлах, Чойрын 220/110/35/6кВ дэд станцын шугамнаас ханган нийлүүлэх боломжтой. Төсөлд нийт 1135 кВт-н цахилгаан ачаалал шаардлагатай. Баяжуулах үйлдвэрийн төслийн үндсэн цахилгаан хэрэглэгчид байна. Үүнд:


1. Баяжуулах үйлдвэр, түүний тоног төхөөрөмжүүд
2. Ажилчдын байр
3. Оффис болон цайны газар гэсэн 3 тусдаа байрлах объектийг тэжээх ба үйлдвэрийн талбайд суурилагдах 1600кВа /ТМ-1600/ чадалтай 2 трансформатор бүхий дэд өртөөнөөс тэнцүү хуваариалан тэжээлийг өгнө.

Усан хангамж

Ус хангамийн эх үүсвэр

“Фен Шу Зун” ХХК-ийн “Нүүрс баяжуулах үйлдвэр” төсөл нь технологийн усны хэрэглээг өөрийн эзэмшлийн 45 болон 100 м-ийн гүнтэй, 2 ширхэг гүний худгаас хангана. Мөн “Давхар амжилт” ХХК-тай байгуулсан ус ашиглах гэрээний дагуу 3.2 л/сек ундаргатай худгаас технологийн болон ахуйн усны хэрэглээг хангахаар төлөвлөсөн.

Зураг 5. Усны эх үүсвэр худгийн байршлын зураг



Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага MNS 6088:2011 стандартын дагуу өрөмдлөг, шавхалт, туршилтын ажлыг явуулах, худгийн усны шахуурга, цахилгаан үүсгүүрийг сонгох, худгийн барилга барих ажлыг гүйцэтгүүлэх шаардлагатай.

Усны хэрэглээ

Унд ахуй: “Нүүрс баяжуулах үйлдвэр” төслийн унд, ахуйн усны хэрэглээ нь гүний ус байна. Нийт 85 ажилчинтай хоёр ээлжээр үйл ажиллагаа явуулах ба хоногт 55 хүн ажиллана. Нэг хүн өдөрт 150 л ус хэрэглэнэ гэж тооцвол унд ахуйн хэрэглээнд хоногт 8.2 тн ус, жилд 2970 тн ус шаардлагатай байна.

Технологийн ус: Нүүрс баяжуулах үйлдвэрийн ус-шлагын тооцооны үр дүнд нийт баяжуулах үйлдвэрийн технологид анхдагч нүүрсэнд агуулагдах усыг хасч тооцсоноор 444 м³/цаг технологийн

ус шаардлагатайгаас 90%-ийг эргэлтэнд буцааж ашиглан үлдсэн 10 % - ийг нэмж өгөх хэрэгтэй болно. Хоногт 1014.93 м3 цэвэр ус татан технологид хэрэглэхээр төсөлд тусгасан байна.

Энэхүү усны их үүсвэрээс үйлдвэрт 11 л/с–н усны зарцуулалттай авч ашиглана. Усан хангамжийн шугам хоолой нь насос станцаар өргөгдөн шугамаар дамжин баяжуулах үйлдвэрийн дэргэдэх усан санд хуримтлагдаж жилийн дөрвөн улирал тасралтгүй үйлдвэрийн хэрэгцээг хангана.

Ногоон байгууламжийн ус: Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 13-р хавсралтын дагуу Зүлэгжүүлэлт, зам талбайн усалгааны норм-д зааснаар 1 м2 цэцэрлэг, зүлэг ногоо услахад 4 литр ус зарцуулагдана гэж тооцвол нэг удаагийн усалгаанд $5800 \text{ м}^2 * 4 \text{ л} = 23200 \text{ л}$ буюу 23.0 м3 ус, нийт 90 удаа усална. Усалгааг 4-р сарын 10-наас 10-р сарын 10 хүртэл өнжөөд нэг удаа буюу сард 15 удаа услахаар төлөвлөсөн.

Зам талбайн усалгаа: Баяжуулах үйлдвэрийн автозамын 10261 м2 талбайг нэг удаа услахад $10261 \text{ м}^2 * 2 \text{ л/м}^2 = 20,522 \text{ л}$ ус ашиглагдана. Тухайн жилийн дулааны улиралд орох хур тунадастай өдрийн тоо хасагдаж тооцогдоно. Зам талбайн усалгааг үйлдвэр ажиллаж буй хугацаанд дулааны улиралд өдөр бүр усалбал жилд $180 \text{ хон} * 20.5 \text{ м}^3/\text{хон} = 3690 \text{ м}^3$ ус зарцуулагдахаар байна.

Зам харилцаа

“Фен Шу Зун” ХХК-ийн “Нүүрс баяжуулах үйлдвэр” төслийн үйлдвэрийн зориулалттай талбай нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт байрлах ба Чойр хотоос зүүн урагш 55 км, Сайншанд хотоос баруун хойш 140 км, төмөр замаас 1 км зайд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын төвөөс 17 км-ийн зайд зам дагуу төслийн талбай байрлаж байгаа юм. Сайншанд-Чойр чиглэлийн хатуу хучилттай замаас салж шороон замаар Нүүрс баяжуулах үйлдвэрт хүрнэ. Төслийн талбайн ойролцоох замын маршрут болон замын хэсгийг дараах зургаар харууллаа.

Зураг 3. Төслийн зам харилцаа





2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


Төслийн байршилтай холбоотой : “Фен Шу Зун ХХК”-ийн төслийн талбайн физик газарзүйн хувьд Говийн их муж, Дорнод говийн дэд муж, Умард говийн ухаа толгодот талын тойрогт хамаарна. Даланжаргалан сум нь ландшафтын хувьд нутгийн зүүн болон өмнөд хэсгээр элэгдэл эвдрэлийн гаралтай уулын нугын, баруун болон хойд элэгдэл эвдрэлийн гаралтай хуурай хээрийн, хуурай хээрийн гандуувтар хэв шинж тархсан байна. Харин нутгийн төв хэсгээр элэгдэл эвдрэлийн гаралтай хуурай хээрийн болон нугат хээрийн хэв шинж тус тус зонхилж байна. Тус төслийн талбай нь одоогоор барилга байгууламж барьж байгуулсан бэлтгэл ажил үйлдвэржилтийн шатандаа явж байгаа бөгөөд дараах нөхцлийг хангаж байна.

Хүснэгт 4. Төслийн байршилтай холбоотой нөхцөл


Нөлөөллийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд	Сөрөг нөлөөлөл үүсч болзошгүй нөхцөлүүд
Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх	Улсын тусгай хамгаалалттай газар нутаг, хуулиар хамгаалагдсан болон орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар нутагтай давхцалгүй.
Хүний нөлөө болон байгаль, цаг уурын өөрчлөлтөд эмзэг, эсэх	Цаг уурын өөрчлөлтөд эмзэг, тухайлбал: - Газрын гадарга эвдэрч нөлөөлөлд өртөнө.
Орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар байгаа эсэх	Байхгүй.
Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсэх эсэх	Төслийн үйл ажиллагааны явцад агаарын бохирдолоор дамжин газрын хэвлийн өнгөн давхарга, хөрсний бохирдол болон ургамлан нөмрөгийн талхагдал бий болно.

Цаг уур, уур амьсгал : Эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсэд багтах ба хоногийн температур эрс хэлбэлздэг, хур тунадас бага, агаарын харьцангуй чийгшилт багатай, хуурайвтар байдаг. Сарын хамгийн бага температур нь нэгдүгээр сард -12°C -оос -25°C , хамгийн өндөр температур нь $+20^{\circ}\text{C}$ -оос $+22^{\circ}\text{C}$ байдаг. Хур тундас бага унадаг, жилд дундажаар 16^0-18^0 мм хүрдэг. Салхины хурд зарим үед $15-18$ м/сек хүрдэг. Нарны цацрагийн жилийн явцаас хамааран сэрүүн бүсэд жилийн дөрвөн улирал ээлжилдэг. Тухайн орон нутгийн хотгор гүдгэр, газрын гадаргын шинж зэргээс хамааран улирлын шинж газар бүр харилцан адилгүй байдаг. Дорноговь аймгийн уур амьсгал нь Монгол орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс шинжтэй. Энд өвөл нь хүйтэн бөгөөд удаан үргэлжилнэ. Зун нь богино, халуун болдог. Хавар, намрын улиралд цаг агаар тогтворгүй эрс өөрчлөгдөж байдаг. Агаарын сарын дундаж температурын агууриг 41.1°C байна. Үнэмлэхүй агууриг нь 67.1°C хүрдэг байна. Агаарын температур тодорхой илэрсэн жил, хоногийн явцтай байдаг. Жилийн явцад агаарын температурын их утга нь зуны 7 дугаар сард, бага утга нь өвөл 1 дүгээр сард тус тус ажиглагддаг байна. Жилийн хамгийн дулаан 7 дугаар сарын дундаж агаарын температур $+20.96^{\circ}\text{C}$ хамгийн хүйтэн 1 дүгээр сарын дундаж температур -19.81°C байна. Агаарын үнэмлэхүй хамгийн их температур $+39.3^{\circ}\text{C}$ хүрч дулаарсан бол үнэмлэхүй хамгийн бага температур -36.9°C хүрч хүйтэрсэн байна.

Зураг 6. Сарын дундаж агаарын температур



Агаарын чанар: Төсөл хэрэгжих талбай орчмын агаарын бохирдлын эх үүсвэр нь түүхий эд тээвэрлэлтээс үүсэх тоосжилт, машин механизмуудын түлшний шаталтаас гарах хорт хий /азотын давхар исэл, хүхэрлэг хий, хар тугалга/, утаа болон цаг агаарын хуурайшилттай үед тэдгээрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрснөөс тоос босох, дуу чимээ зэрэг болно. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт бүхэлдээ салхи ихтэй нутагт хамрах бөгөөд жилийн салхины дундаж хурд нь 5-6.8м/с хооронд хэлбэлзэн. Энд салхины хамгийн хурдтай 4-5 сард ажиллагдаг бөгөөд энэ үед салхи 20- 24м/с хүрдэг байна. Тус сумын нутгаар жилдээ 15м/с дээш хүчтэй салхитай байх хоногийн тоо 19-25 өдөр байдаг. Салхи салхилах зонхилох чиглэлийг улиралын дундах саруудаар авч үзвэл тухайн нутагт дийлэнх тохиолдолд хойд, баруун хойд, баруун зүгийн салхи зонгилдог. Салхины хурд хөрсний байдалтай уялдан шороон шуурга болох нь газар бүр харилцан адилгүй.



Гадаргын болон гүний ус: “Фен Шу Зун” ХХК-ийн “Нүүрс баяжуулах үйлдвэр” төсөл нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт хэрэгжинэ. Монгол орны гол, мөрөн, түүний сав газрын хэмжээ, байгалийн нөхцөл, урсац бүрэлдэх зүй тогтол, нөөцийн хуваарьлалт, байгалийн болон засаг захиргааны хил хязгаарыг үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын

сайдын 2009 оны 332 дугаар тушаалаар Монгол орны нутаг дэвсгэрийг усны 29 сав газарт хувааж, хил хязгаарыг нь тогтоож өгсөн байдаг бөгөөд тус төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь Умард говийн гүвээт Халхын дундад талын сав газарт хамаарна. Тус сав газар нь Монгол орны 29 усны сав газрын хувьд талбайн хэмжээгээрээ 2 дугаарт орох бөгөөд далайн төвшнөөс дээш дунджаар 1267 метр өргөгдсөн өргөн уудам тал нутаг юм.

Монгол орны 1:1'000'000 масштабын гидрогеологийн зурагт Зүүн Далангийн талбайн тунамал хурдсыг газрын доорх усны локал, хязгаарлагдмал нөөцтэй бүсэд хамааруулсан байдаг. Мөн эргэн тойрны болон ул суурийн вулканик чулуулгууд нь ерөнхийдөө газрын доорх усгүй чулуулгаар зураглагдсан байна. Хайгуулын лицензийн талбайд газрын доорх ус агуулагч чулуулгийн стратиграфийн ангилал, найрлага, газрын доорх усны хөдөлгөөн, тархалт, байрлалын нөхцлүүдээс хамааран дараах 3 уст үе, давхаргад ялгав. Үүнд:

- Дөрөвдөгчийн сэвсгэр хурдсанд агуулагдах бага гүний уст үе
- Цэрдийн тунамал чулуулаг дахь уст давхарга (Зүүнбаянгийн давхаргадас)
- Хожуу Юра-Түрүү Цэрдийн экструзив вулканик чулуулаг дахь уст давхарга (Цагаан цав давхаргадас).

Фен Шу Зун” ХХК-ийн “Нүүрс баяжуулах үйлдвэр” төслийн талбай байрлах орчны газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөцийн хувьд жилд 5 мм-ээс бага байна.

Төслийн талбай дах газрын доорх усны чанарыг тогтоох зорилгоор худгийн уснаас дээжлэлт хийн шинжлүүлсэн бөгөөд “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018” стандартад заасан хэмжээнээс их байгаа тул хүний ундад тохиромжгүй байгаа тул цэнгэгжүүлж, зөөлрүүлж хэрэглэх шаардлагатай гэж гарсан байна.

Хөрс: Төслийн талбайд хамаарах газар нь 1157-1163 метрийн үнэмлэхүй өндөртэй талархаг хөндий бүхий газарт байрлана. Төслийн талбайд тархсан хөрсөн бүрхэвч нь монгол орны хөрсний ангиллаар хээрийн бүлэг хөрсний Цайвархүрэн хөрсний хэвшинжид багтах Мараалаг Цайвархүрэн, Сайргархаг Цайвархүрэн хөрс зонхилон тархсан байна. Төслийн талбайн хөрсний хими, физик шинж чанараар судлан үзэхэд жижиг чулууны бүрхэц 10-20%, ургамал бүрхэц 30-40%, бага зэрэг элсэн хуримтлалтай, техникийн нөлөөтэй эвдрэл талхагдал багатай, газрын гадарга нь хойноос урагшаа чиглэсэн 1-2 градус налуу гадаргатай, дов сондуул бага байна.

Төслийн талбайд хээрийн бүлэг хөрсний Цайвархүрэн хөрсний дэд хэв шинжид багтах Мараалаг Цайвархүрэн хөрс зонхилон тархсан байна. Цайвархүрэн хөрс нь үржил шимийн түвшин бага, бэлчээрт зонхилон ашиглагддаг бөгөөд бүтцийн тогтворшилт хэврэг, байгалийн болон хүний хүчин зүйлсийн нөлөөгөөр амархан талхагдах магадлалтай, эмзэг ангилалд ордог, байгалийн аясаараа нөхөн сэргэх чадамж сулд тооцогдоно. Төслийн талбайн хөрсөн бүрхэвч нь өнөөгийн байдлаар тослох материалын цэгэн болон нүүрсний тоосонцорын хэсэг хэсэг хучаас бүхий бохирдолтой, soil-2 хүнд металлын шинжилгээнд хүнцэлийн агууламж хүлцэх агууламжаас

хэтэрсэн бохирдолтой, төслийн талбай бүхэлдээ ашиглагдаж багаас хүчтэй талхагдсан байна. Мөн нүүрсний тоосонцорын тархалт нь төслийн талбайгаар хязгаарлагдахгүй ойр орчмын газруудад нөлөөлж байна.

Ургамлан нөмрөг: Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Фен Шу Зун” ХХК-ийн “Нүүрс баяжуулах үйлдвэр” төслийн талбай нь ургамал -газарзүйн тойргоор Дундаж Халхын хээрийн тойрогт байрлах боловч Дорно–Говийн цөлөрхөг хээрийн тойрогт шилжих хил залгаа бүс нутагт байрлаж байна. Энд хойноосоо Дундад халхын хээрийн үет ургамлын төлөөлөл өмнөөсөө цөлөрхөг хээрийн жижиг сөөг сөөгөнцөр ургамлын төлөөлөл тохиолдох онцлогтой. Төслийн талбай нь Монголын төв хэсгийн боржин бүхий бэсрэг уулс, ухаа гүвээрхэг толгод хоорондын дэрстэй нарийн хоолойд байрлаж байна.

“Фен Шу Зун” ХХК-ийн “Нүүрс баяжуулах үйлдвэр” төслийн дийлэнх талбайд ургамал бүрхэвч дарагдах болон талхлагдах нөлөөлөлд өртөж ургах нөхцөлгүй болсон байдалтай байна.

Зураг 7. Төслийн талбайн еранхий төлөв байдал



Амьтны аймаг: Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг нь амьтны аймгийн мужлалаар Монгол дагуурын тойрогт хамаардаг (Банников,1954). Баяжуулах үйлдвэр байрлах газар нутаг нь Таана-Гялгар дэрс бүхий ургамлын хэвшил зонхилсон хөндийд байрлах ба энд Бор туулай, махан идэшт амьтад болох Шар үнэг, Хярс үнэг, Саарал чоно зэрэг амьтад өдрийн цагаар орогнож нуугдахаас гадна Монгол чичүүл, Орог зусаг, Хөх шишүүхэй гэх мэт мэрэгч амьтдын шүтэн байршдаг чухал амьдрах орчин юм.

Тухайн район ан амьтад элбэг, махчин амьтаас үнэг, хярс, дорго, мануул, хааяа чоно, мэрэгчээс үлийн цагаан огтоно, ольби, орог саарал, шар сүүлт, алаг даага, туулай зэргийг нэрлэж болно.

“Фен Шу Зун” ХХК-ийн “Нүүрс баяжуулах үйлдвэр” төслийн талбай нь авто зам, Төмөр замын өтрөөнд ойр орших тул зэрлэг амьтад маш ховор тааралдана. Барилга барих үйл ажиллагааны улмаас тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, барилга байгууламжуудыг барих явцад амьтдын нүх, үүр сүйтгэгдэх, нүх, үүрнээсээ дайжиж болзошгүй. Төслийн үйл ажиллагааны явцад хүн амын

суурьшлыг дагаад хоол хүнсний хаягдлаар хооллодог бор шувуу, хэрээ зэрэг суурин газрын шувуудын цугларалтыг нэмэгдүүлж болох юм.

Нийгэм эдийн засгийн төлөв байдал: Дорноговь аймгийн Даланжаргалан сум нь 402.5 мян.га талбай нутаг дэвсгэртэй, Улаанбаатар хотоос 300 км, аймгийн төв Сайншанд сумаас 156 км-т, Улаанбаатар Замын-Үүд чиглэлийн төмөр зам болон хатуу хучилттай авто замын дагуу байрлах ба нутгийнхаа баруун болон хойд талаараа Дундговь, Говьсүмбэр, Хэнтий аймгуудтай, бусад талаараа өөрийн аймгийн Айраг, Иххэт сумдтай хиллэн оршдог. Тус сум нь засаг захиргааны анхан шатны Элдэв, Өнгөт, Бичигт, Цомог, Олон-Овоо гэсэн 5 багтай, 3005 хүн амтай, 215240 толгой малтай. Төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдож, үүрэн телефоны сүлжээ нэвтэрсэн. Тус суманд 320 хүүхдийн Ерөнхий боловсролын сургууль, 60 ортой дотуур байр, 12 ортой хүн эмнэлэг, 195 хүүхдийн хүчин чадалтай Даланжаргалан болон Олон Овоо багийн 2 цэцэрлэг, 250 суудалтай соёлын төвтэй. Тус сумын эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй боловч сүүлийн 10 гаруй жил уурхайн салбар эрчимтэй хөгжиж байгаа сумдын нэг бөгөөд цаашид уул уурхай, үйлдвэрлэл, дэд бүтэц дагасан шилжилт хөдөлгөөн нэмэгдэх, хүн ам эрчимтэй нэмэгдэх боломж бүрдсэн байна.

“Фен Шу Зун” ХХК-ийн “Нүүрс баяжуулах үйлдвэр” төслийн талбайн ойролцоох суурьшлын бүс нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын төв байна. Иймд, орон зайн хувьд авч үзвэл эдгээр суурьшлын бүсэд төслийн барилгажилт болон нүүрс баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй. Харин төслийн талбайтай ойролцоо айл өрх байхгүй, ойролцоох үйл ажиллагаа явуулж буй байгууллагын ажилчдад барилгажилт, ашиглалтын үед нөлөөлөлд өртөж болзошгүй. Нүүрс баяжуулах үйлдвэр байгуулагдсанаар улс орны төсөвт татвар төлөх, нүүрсний экспортыг нэмэгдүүлэх, орон нутгийн төсөвт хувь нэмэр оруулах, төслийн үйл ажиллагаа эхэлснээр төслийн талбайн нутагт оршин суугч иргэдээс ажилд авах, тогтмол орлогын эх үүсвэртэй болгох шинээр 80-85 ажлын байр бий болгоно.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Нүүрс баяжуулах үйлдвэрийн жилийн хүчин чадал жилд 1000 мян.тн нүүрс баяжуулах бөгөөд 30 хүртэлх үндсэн бөгөөд туслах тоног төхөөрөмжүүдийг суурьлуулан үйл ажиллагаа явуулна. Төслийн талбайд түүхий нүүрсний овоолго, баяжуулсан нүүрсний талбай, хаягдал хурдас түр хадгалах талбай, авто зогсоол, оффис барилга, авто жин, баяжуулах үйлдвэр, пүүний байр зэрэг шаардлагатай барилга байгууламжуудыг барьж байгуулсан байна. Нүүрс баяжуулах үйлдвэрт нийт 85 хүн ажиллахаар төсөлд тусгасан болно.

2022 онд баталгаажсан төслийн БОННУ тайланд дараах байдлаар төслөөс байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхээр тусгасан байна.

Байгаль орчин, нийгэм-эдийн засагт үзүүлэх гол нөлөөллүүдийн хураангуй

Тухайн төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хэвлийд нөлөөлөх нөлөөллийн хэмжээ нь нийт 35352.1 метр квадрат /3.53 га/ талбай байгаагаас түүхий нүүрсний овоолго, баяжуулсан нүүрсний талбай, хаягдал хурдас түр хадгалах талбай, авто зогсоол, оффис барилга, авто жин, баяжуулах үйлдвэр, пүүний байр зэргийг барихад дарагдах хэлбэрээр шууд нөлөөлөлд өртсөн байна. Төслийн хашаан доторх зам талбайн өнгөн хөрсөнд үүсэх эвдрэл талхагдал ба бүтцийн алдрал, талбайгаас үүсэх тоосонцорын тархалт, авто зогсоол орчимд үүсэх шатах тослох материалын цэгэн бохирдол гэсэн өдөр тутамд үүсч байгаа гол сөрөг нөлөөллөөс гадна ахуйн гаралтай органик ба хатуу, шингэн хог хаягдалаас үүсэх механик бохирдол ба 00 орчмоос үүсэх нянгийн бохирдол гэсэн болзошгүй сөрөг нөлөөллүүд байна. Гол сөрөг нөлөөллүүдээс тоосонцорын тархалт нь төслийн талбайгаар хязгаарлагдахгүй ойр орчмын газарт нөлөөлж байна. Гэхдээ энэ нөлөөлөл нь зэргэлдээх ижил үйл ажиллагаатай төслүүдээс үүсэх тоосжилттой хавсарсан байдлаар орчиндоо нөлөөлж байна гэж БОННУ тайлангаар дүгнэгдсэн байна.

1. Төслийн байршилтай холбоотой

Төслийн талбайд үйлдвэрлэлийн барилга байгууламжийг барих үйл ажиллагаа хийгдэн аль хэдийн газрын гадарга хөрсөн бүрхэвч ургамлан нөмрөгт сөрөгнөлөөлөл үзүүлсэн бөгөөд цаашид нэмэлтээр барилга байгууламж барих үеийн эвдрэл гэмтэл бага байна. Мөн төслийн байршилтай холбоотой сөрөг нөлөөлөл бага байна. Гэхдээ машин техник, хүний хөл хөдөлгөөний улмаас эвдэрсэн газрын хөрсийг сэргээх, ургамалжуулах ажлыг хийж унаган төрхөнд нь ойртуулан нөхөн сэргээх, орчны тоосжилтыг бууруулах талаар анхаарч ажиллах шаардлагатай.

2. Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Нүүрс баяжуулах үйлдвэрийн шинээр барилга байгууламж барих, овоолгын үе газар шорооны ажлаар (барилгын суурь ухах, шуудуу ухах г.м) газрын гадарга, хэвлийд бага хэмжээний өөрчлөлт орно. Шинээр барилга байгууламж барихаар газар шорооны ажлыг эхлүүлэхэд газрын гадарга, хэвлийд бага хэмжээний сөрөг нөлөө үзүүлэхээр байна. Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх гол нөлөөлөл нь барилга байгууламжийг байгуулахад ухагдах талбай болон барилгын ажлын явцад

ашиглагдах машин техник газрын гадаргыг талхлах байна. Нүүрс баяжуулах үйлдвэр төслийн үйл ажиллагааны хүрээнд нөлөөлөлд өртөх талбайгаас нөлөөллийн их ангилалд 10.59 га, дунд ангилалд 5.37 га, бага ангилалд 24.9 га талбайг тус тус эзэлж байна.

3. Агаарын чанар

Баяжуулах үйлдвэрийн ажиллагаанаас ялангуяа нүүрсний хүлээн авах талбайд нүүрс буулгах, тунаах машиныг туузан дамжуургаар тэжээх, баяжуулсан нүүрс болон хаягдлыг ачих ажиллагаанаас тоосжилт үүснэ. Баяжуулсан нүүрсний овоолго үүсгэх явцад болон нүүрс ачиж буулгах үйл ажиллагаанаас тоосжилт харьцангуй бага үүсдэг ба энэ нь баяжуулсан нүүрс тодорхой хэмжээний чийгтэй байдагтай холбоотой юм. Гэхдээ удаан хугацаагаар хадгалагдсан баяжуулсан нүүрсний овоолгуудаас болон нүүрсний тоосоор бүрхэгдсэн нүүрс ачих талбайгаас салхины үйлчлэлээр болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр тоосжилт үүсдэг байна. Дараах хүснэгтэд баяжуулах үйлдвэрээс агаарт тоос үүсгэх эх үүсвэр болон ялгарлын хэмжээг үзүүлэв.

Хүснэгт 5. Нүүрсний үйлдвэрээс тоосжилт үүсгэх эх үүсвэрүүд

№	Төслийн үйл ажиллагааны төрөл	Ялгарлын хэмжээ, тн/жил	
		Нийт тоос	PM10 тоосонцор
1	Нүүрсний талбай автосамосвалаар нүүрс буулгах	8.75	3.6
2	Утгуурт ачигчаар нүүрс ачих	20.2	9.7
3	Туузан дамжуургаар овоолгод баяжуулсан нүүрс буулгах	2.8	1.1
4	Туузан дамжуургаар хаягдал буулгах	0.7	0.3
5	Нүүрсээр бохирдсон талбайн салхины элэгдэл	4.825	2.0
Төслийн үйл ажиллагаанаас жилд үүсэх тоос тоосонцрын хэмжээ, тн		37.3	16.9

Баяжуулах үйлдвэрээс гарсан бүтээгдэхүүнийг тээвэрлэх хүртэл задгай талбайд хадгалж байна. Талбай ажиллаж буй дугуйт ачигч, тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөн, салхины элэгдлээр тоосжилт үүснэ. Баяжуулах үйлдвэрийн талбайн хэмжээнд үүсэх нийт тоосны ялгарлын хэмжээ төслийн хугацаанд 373.0 тн гэж тооцсон байна. Нүүрс баяжуулах үйл ажиллагаанаас үүсэх тоосны ширхэглэгийн бүрэлдэхүүнд том хэмжээтэй буюу масс ихтэй тоос ихээр агуулагдах тул эх үүсвэрээс төдийлөн алслахгүйгээр газарт эргэн унадаг байна. баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт орчны агаар дахь PM10 тоосонцрын хоногийн дундаж агууламжийг хамгийн ихдээ 606 мкг/м³ хүртэлх хэмжээгээр илрэхээр байна. Баяжуулах үйлдвэрийн нүүрс ачиж буулгах талбай орчим тоосны агууламж ерөнхийдөө их байх ба төслийн талбайгаас 2.5 км хүртэлх зайд орчны агаар дахь PM10 тоосонцрын хоногийн дундаж агууламжийг 10-400 мкг/м³-р нэмэгдүүлж байна. Иймд өдөр тутмынагаарт ялгарах бохирдлын хэмжээг тооцож бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Төслийн үйл ажиллагаанаас агаар орчинд нөлөөлж болзошгүй нөлөөлөл нь авто тээврийн хэрэгслийн яндангаас гарах утаа, бүх төрлийн хог хаягдлыг шатаах, хог хаягдлын цэгийн орчинд эвгүй үнэр гарах, амьдрах орчны тав тухыг алдагдуулах зэрэг байхаар байна. Мөн төслийн барилгын ажлын явцад тоосжилт ихсэж ойр орчмын хүн ам, ургамлан нөмрөгт нөлөөлөл үзүүлнэ.

4. Төслөөс гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл

“Фен Шу Зун” ХХК-ийн Нүүрс баяжуулах үйлдвэр төслийн үйл ажиллагааны улмаас газрын доорх усанд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөлд бүх төрлийн тээврийн хэрэгслийн ШТМ-ын алдагдал, хатуу болон шингэн хог хаягдлын цэгийн ойр орчмын хөрсний бохирдол нь бага гүний уст үеүдийг бохирдуулах, төслийн ус хэрэглээний улмаас төслийн талбайн хэсэг дэх газрын доорх усны нөөц хомсдох, хатуу болон шингэн хог хаягдлын цэгийн орчимд тэргүүн ээлжинд хөрс, ургамал бохирдож, улмаар агаарын хур тунадасны угаагдлаар газрын доорх усанд бохирдол үүсэх боломж бүрдэж болзошгүй байна.

5. Төслөөс хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл

Өнөөгийн байдлаар төслийн талбайн хөрсөнд хүнд металлын болон биологийн онц ноцтой бохирдол үүссэн тохиолдол байхгүй, харин тоосонцороос үүдэлтэй бага зэрэг органик бохирдол талбай орчмын өнгөн хөрсөнд үүссэн байна. Одоогоор төслийн хашаан доторх ердийн шороон зам талбайн өнгөн хөрс хүчтэй эвдэрч талхагдсан байна. Цаашид төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид элэгдэл эвдрэл, талхагдал гэсэн үндсэн 2 сөрөг нөлөөлөл ба тоосны тархалт гэсэн дам сөрөг нөлөө өдөр тутамд үүснэ. Харин хаягдал тослох материал болон хүнсний хаягдал ба ахуйн бохир зэргээс хөрсөнд органик болон нянгийн бохирдлын болзошгүй сөрөг нөлөөлөл үүсэх магадлалтай байна.

Үйлдвэрийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид эвдрэл, бохирдлын дараах түгээмэл хэлбэр, өөрчлөлтүүд үүснэ. Үүнд:

- Хөрсний шимт бодисын нөөц хомсдох;
- Хөрсний гадаргын ургамал бүрхэц сийрэгжсэнээр хөрс эвдрэх үйл явц түргэсэх;
- Хөрсний хими, физик, геохими, биохимийн хөдлөл зүйн горим өөрчлөгдөх;
- Үйлдвэрийн явцад болон үйлдвэрийн орчинд хэрэглэх усанд өнгөн хөрс идэгдэж, угаагдах;
- Механик үйлчлэлээр хөрс (машины дугуй, хүний хөл) талхлагдаж сийрэгжих, нимгэрэх;
- Хог ургамалд баригдах, доройтох, цөлжих;
- Хөрс хуурайшиж, бүтэц нь алдагдах;
- Ахуйн хогоор бохирдох;

6. Төслөөс ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төслийн талбайн орчинд тоосжилт нэмэгдсэнээр ургамлын фотосинтезийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж өсөлт хөгжил буурах, сийрэгших, хөл газрын ургамлын төрөл зүйлүүд ихээр ургах сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй байна. Олон машин техникийн хөдөлгөөнөөр олон салаа зам үүсэх, тухайн орчны хэт талхлах зэргээр ургамлан нөмрөгт сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.

7. Төслөөс амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаа машин техникийн дуу чимээ, ажилчдын хөл хөдөлгөөн нэмэгдсэнээс, тоос шороо, техникийн шатахууны үнэр зэрэг нь амьд амьтан тэнд байх экологийн нөхцөлгүй болохоос

гадна нутгийн зэрлэг амьтдад шууд физик үйлчлэл, техногенезийн стресс үүсэх, бэлчээр, тэжээлийн хомсдол гарах зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

8. Төслөөс нийгэм-эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

“Фен Шу Зун” ХХК-ийн “Нүүрс баяжуулах үйлдвэр” төслийн талбайн ойролцоох суурьшлын бүс нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын төв байна. Иймд, орон зайн хувьд авч үзвэл эдгээр суурьшлын бүсэд төслийн барилгажилт болон нүүрс баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй.

Харин төслийн талбайтай ойролцоо айл өрх байхгүй, ойролцоох үйл ажиллагаа явуулж буй байгууллагын ажилчдад барилгажилт, ашиглалтын үед нөлөөлөлд өртөж болзошгүй. Нүүрс баяжуулах үйлдвэр байгуулагдсанаар улс орны төсөвт татвар төлөх, нүүрсний экспортыг нэмэгдүүлэх, орон нутгийн төсөвт хувь нэмэр оруулах, төслийн үйл ажиллагаа эхэлснээр төслийн талбайн нутагт оршин суугч иргэдээс ажилд авах, тогтмол орлогын эх үүсвэртэй болгох шинээр 80-85 ажлын байр бий болгоно.

Төслөөс нийгэм эдийн засгийн хөгжилд үзүүлэл нөлөөлөл

Төслийн үндсэн үйл ажиллагаанаас байгаль орчны дэд бүрдлүүдэд багаас дунд зэргийн сөрөг нөлөөлөл үзүүлэх бөгөөд үйлдвэрт ажиллах ажилчдын эрүүл мэнд аюулгүй байдлыг хангаж ажилласнаар бага зэргийн сөрөг нөлөөллийг үзүүлж болзошгүй гэж дүгнэгдсэн байна. Мөн хүн нийгмийн орчинд дараах эерэг нөлөөтэй байна.

- Оршин суугчид нөлөөллийн бүсийн гадна талд байрлах учир газар ашиглалтын эрх зөрчигдөхгүй.
- Төсөл хэрэгжсэнээр нутгийн иргэд тодорхой хэмжээнд ажлын байраар хангагдана.
- Хамгийн ойр орших суурин газар нөлөөллийн бүсийн гадна байгаа тул сөрөг нөлөөлөлд өртөхгүй.
- Санхүүгийн орлого нэмэгдэх;
- Дэд бүтэц хөгжих;

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

2023 онд нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийг хэрэгжүүлж ажиллахад БОННУ-д тусгагдсан сөрөг нөлөөллийг байгаль орчинд учирч болох нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, үүсэх эрсдлийг бууруулах, БОМТ-д заагдсан ажлуудаас хийж хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааг явуулах болно.

Нөхөн сэргээлт

Барилгын болон ашиглалтын үед техноген эвдрэл элэгдэлд орсон хөрсийг дахин нөхөн сэргээх техникийн шаардлага тавигдана. Үүнд:

- Жил бүрийн уулын ажлын төлөвлөгөөнд эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн ажлын хэмжээг тодотгон, шаардагдах зардлыг тооцож байх
- Нөхөн сэргээлтийн ажилд дараахь стандарт болон заавруудын шаардлагыг хангах. Үүнд:
- MNS 5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томъёо, тодорхойлолт.
- MNS 5915:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал.
- MNS 5916:2008 Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт.
- Ашигт малтмал эрж хайх ажлын явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээж ургамалжуулах заавар (БО-ны болон ХААҮ-ийн сайдын 2000 оны 64/А/62 тоот тушаалын 3-р хавсралт)
- Нөхөн сэргээгдэж буй газар, түүний хүрээлэн буй орчин нь олборлолтын дараа байгалийн тэнцвэрт байдлаа хадгалсан, унаган төрхөндөө ойртсон, хүн амьтны эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байх нөхцлийг аль болох эртнээс төлөвлөх.

ТЭЗҮ-д тусгагдсанаар эвдэрсэн газрыг тэгшилж, дараа нь шимт хөрсөөр хучих ба биологийн нөхөн сэргээлтийн ажлыг га тутамд нь 4.5 сая төгрөгөөр мэргэжлийн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэхээр тусгасан байна.

Техникийн нөхөн сэргээлт: Ашиглалтын үед ашиглагдаж буй барилга байгууламж болон бусад нөлөөлөлд өртсөн талбайн нөхөн сэргээлтийг төслийн үндсэн үйл ажиллагаа бүрэн дууссаны дараагаар хаалтын үе шатанд хийгдэхээр төлөвлөсөн байна. Харин ашиглалтын жилүүдэд нүүрс буулгах талбайд үүссэн овоолго тэгшлэх хэлбэржүүлэх техникийн ажлыг хийж гүйцэтгэх бөгөөд 2023 онд үүсэх овоолгын хэмжээгээр техникийн нөхөн сэргээлт хийгдэх зардлыг тусган оруулав.

Техникийн нөхөн сэргээлтэнд ажиллах бульдозерын ажилд гадаад овоолгын хажууг 18 градус болгон налуулж хэвгийжүүлэх техникийн ажил багтана.

Биологийн нөхөн сэргээлт: Тус төслөөс ямарваа нэг уурхайн олборлолт хийгдэж газар хөндөгдөхгүй бөгөөд ашиглалтаас үүдэн эвдрэлд элэгдэлд өртсөн талбайд шаардлагатай техникийн нөхөн сэргээлтийг хийсний дараагаар биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийнэ. Иймд 2023 онд техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэхээр байна.

Ногоон байгууламжийн төлөвлөгөө: Тухайн төслийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой агаарын орчин болон төслийн талбайд тоосжилт үүсгэх учир агаарт үүсэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгаж, орчныг цэвэр эко байлгах үүднээс төслийн талбайд ногоон байгууламжийг бий болгоно. 2023 онд тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хрээнд сонгогдсон талбайд 100ш улиас мод тарих бол төслийн талбайд 50 ш улиас мод тарьж хашаажуулан услан, арчилж тордох ажлыг төлөвлөн холбогдох зардалыг тусгалаа.

Ногоон байгууламж бий болгохтой холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Ногоон ургамлыг хамгаалалтын бүс, барилга байгууламжийн дэвсгэр газрын зааг болгох зэргээр боломжтой газар бүхэнд ашиглаж тариалана.
- Нүүрс баяжуулах үйлдвэрийн талбайд хамгаалалтын ногоон зурвас /ногоон байгууламж/ байгуулахдаа салхин дээд талд говь цөлийн нөхцөлд ургах чадвар өндөртэй, модлог ургамлууд болох Хайлаас, Жигд, Сухай, харгана зэрэг ургамлыг түлхүү тариалах нь илүү үр дүнтэй учир 2023-2024 онд төслийн талбайд хайлаас модны үр суулган ногоон байгууламж бий болгоно.
- Усалгаа: Усалгаа нь төслийн талбай дахь ашиглалтгүй талбай, овоолгуудаас үүсэх тоосжилтын бууруулахад хэрэглэгддэг гол арга юм. Төслийн талбай ойр орчимд үүсэх тоосжилтыг бууруулах болон ногоон байгууламжид усалгаа гол нөлөөтэй бөгөөд усалгааг тогтсон цагт цаг агаарын нөхцөлтэй уялдуулан хийхээр байна.

Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө: Техник технологи галын аюулгүй байдлын бүрэн хангуулах, болзошгүй осол эрсдэлийн үед ажилчдыг болон шаардлагатай техник тоног төхөөрөмжийг бэлэн байхад бэлтгэх зэрэг ажлыг энэ онд хийж гүйцэтгэхээр төлөвлөн хийгдэх хугацаа болон ажлын зардлын хамт төлөвлөлөө.

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө: Тухайн төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний төлөвлөгөө: Төслийн талбайд хог хаягдлын бохирдол үүсгэхээс сэргийлж төвлөрсөн хог хаягдлын цэгтэй болж, битүүмж сайтай хогийн сав суурилуулан ажиллахаар төлөвлөлөө. Мөн хог хаягдлын бохирдол үүсгэхээс сэргийлж ажилчдад сургалт орох, байнгын хяналтыг тавьж ажиллахаар төлөвлөж холбогдох зардлыг тусгав.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө: БОННУ тайланд тусгагдсан ажлуудын дагуу 2023 онд ТХГ-н чадавхи менежментийг сайжруулах ажлын үүднээс холбогдох мэргэжлийн байгууллагатай тохиролцон шаардлагатай ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Мөн төслийн талбайн ойролцоо ногоон байгууламж бий болгон хашаажуулан нийт 100 ширхэг мод тарьж арчилхаар төлөвлөв.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр: Тус хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг хариуцан хийнэ.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг БОННУ тайланд тусгагдсан орчны хяналт шинжилгээний цэгт, давтамжын дагуу хийх бөгөөд агаарын бохирдол тоосны шинжилгээг жилд 4 удаа төсөл хэрэгжих талбайн зонхилох салхины дээд доод талд хяналтын 2 цэг сонгон хийнэ.

БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр БОМТ -ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлэн ажиллана.

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт байрлах Нүүрс баяжуулах үйлдвэр байгуулах төслийн 2023 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
АГААРЫН ОРЧИНД							
	Хатуу хучилтгүй зам дээрх машинаас үүсч болох шороо тоосноос агаарт тоосжилт үүсэх	Хучилтгүй зам дээр тээвэр хийх машины хурдыг хязгаарлаж, хурдны хязгаарлалтыг анхааруулсан замын тэмдэг, тэмдэглэгээ байршуулна	Шороон замуудад	150.0	450.0	2023	Агаарын тухай хууль, 9, 11, 23-р зүйл MNS 4585:2007
	Үйлдвэрийн талбай дахь нүүрсний овоолгоос тоосжилт үүсэх	Нүүрсний овоолгод хаалт хийх, хаалтны бүрэн бүтэн байдлыг хангах	Нүүрс ачиж буулгах, хадгалах талбай	400.0	2,000.0	2023	Агаарын тухай хууль, 9, 11, 23-р зүйлд MNS 4585:2016
					2 450.0		
ГАДАРГЫН БОЛОН ГҮНИЙ УС							
1	Унд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар усыг хэмжээгээр ашигласнаар усны нөөцөд сөргөөр нөлөөлөх	Унд ахуйн хэрэглээнд ашиглах усыг арвилан хэмнэх, ус хэмнэлтийн менежментийг хэрэгжүүлэх.	Үйлдвэрийн ажилчид	--*--	--*--	Төсөл хэрэгжиж эхлэснээс хойш тогтмол	Усны тухай хууль: Зүйл 24-1.1, 1.2; Зүйл 30; Зүйл 31-1, 2, 3, 4, 5, 6, 8; Зүйл 33-1, 2, 3; Зүйл 34-1, 2; Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага” MNS4596:1998. БОНБНУ, Компанийн дотоод журам, Усны менежментийн төлөвлөгөө
2		Ус ашиглах хэсгийг тоолууржуулах	Гүний худаг	--*--	--*--	Ашиглалтын 1-р жилд цаашид төсөл хэрэгжих хугацаанд тогтмол	

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт байрлах Нүүрс баяжуулах үйлдвэр байгуулах төслийн 2023 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
3		Гүний усны ашиглалтын худгийг барилгажула, эрүүл ахуйн бүс тогтоох	Төслийн үйл ажиллагаанд	2 000.0	2 000.0	Ашиглалтын 1-р жилд	
НИЙТ				2 000.0			
НИЙТ ЗАРДАЛ				4 450.0			

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 онд төслийн талбайд нүүрсний овоолгод техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэх бөгөөд нийт 0.9 га талбайтай дүйцэхүйц овоолгыг зөөж хэлбэржүүлэх ажлыг хийж гүйцэтгэнэ. Техникийн нөхөн сэргээлтийн ажлын зардалд нийт 4.0 сая төгрөгийг зарцуулахаар байна.

7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн төслийн эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол үйл ажиллагааг түр зогсоон зохих мэргэжлийн байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулж ажиллана.

9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөн хүрээнд үндсэн 3 хүртэлх болзошгүй осол эрсдлийн сөрөг нөлөөллийн хүрээнд 9 хүртэлх урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээний ажлыг төлөвлөж нийт 1.1 сая төгрөгийн зардлыг гарган ажиллахаар байна.

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Түлшний агуулах, засварын газар, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй	Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар дүрэм, журам боловсруулж мөрдлөг болгон ажиллах.	ҮАЗ	-
		Бүх ажилчдыг гал түймэр унтраах мэргэжлийн сургалтад хамруулах.	ҮАЗ	Жилд 1 удаа
		Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байршуулах.	600.0	Ашиглалтын 1-р жилд /тогтмол/
		Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах	-	Ашиглалтын 1-р жилд /тогтмол/
2	Үйлдвэрлэлийн осол, аваар, ажилчид бэртэх, эрүүл мэнд	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах	-	Өдөр бүр ээлжинд гарахын өмнө

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт байрлах Нүүрс баяжуулах үйлдвэр байгуулах төслийн 2023 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
	хохирох, амь нас эрсдэх, үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	ҮАЗ	Ашиглалтын 1-р жилд /тогтмол/
		Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг машины кабин, ажлын байрт байршуулах.	500.0	Жил бүрийн I улиралд байрлуулан сар бүр шалгаж байх
		Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах.	ҮАЗ	Жил бүр
3	Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс машин техникүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх гэх мэт осол аваар гарах	- Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах - Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах - Талбай дотод таних тэмдэг тэмдэглэгээг байрлуулах	Сөрөг нөлөөллийг бууруулах зардалд тусгасан	Жил бүр, жилд 1 удаа
Нийт зардал			1 100.0	

11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нүүрс баяжуулах үйлдвэр ашиглах төслийн үйл ажиллагаанаас гарч буй хатуу, шингэн, төлөв байдлын бүх төрлийн хог хаягдлуудын зохицуулалтад, Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартууд, байгууллагын дотоод журмыг мөрдөн ажиллана.

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт байрлах Нүүрс баяжуулах үйлдвэр байгуулах төслийн 2023 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал мян.₮	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Ахуйн хаягдлыг ангилах, дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авах.	Ашиглалтын 1-р жилээс тогтмол	Үйл ажиллагааны зардалд	4цэгт 4 сав 1 600.0	Төсөл хэрэгжих хугацаанд	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008
2		Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдын байр, ШТС зэрэг газарт байршуулах.	Ашиглалтын 1-р жилд				
3		Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан, ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Ашиглалтын 1-р жилээс тогтмол	Гэрээний дүнгээр			
4		Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт өгөх.	Ашиглалтын 1-р жилээс тогтмол				
5		Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Ашиглалтын 1-р жилээс тогтмол	Үйл ажиллагааны зардалд			
6		Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах	Ашиглалтын 1-р жилд	Үйл ажиллагааны зардалд			
НИЙТ ДҮН					1 600.0		

12. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд ТХГ-н менежментийг сайжруулах ажлыг орон нутагтай харилцан тохиролцож хийх бөгөөд тэрбум мод тарих ногоон байгууламж бий болгох ажлын хүрээнд 100 ш улиас модыг төслийн талбайгаас 5-10км зайд тарьж ургуулахаар тусгалаа.

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал мян.₮	Хугацаа ба давтамж
Цөлжилтөөс сэргийлэх, тэрбум мод	Сонгогдсон цэгт 100ш хайлаас мод тарьж, арчилна.	Ашиглалтын 1-р жилд		2 000.0	2023 онд
Ногоон байгууламж	Төслийн талбайд ногоон байгууламж бий болгож, арчилна.	Ашиглалтын 1-р жилд		1 000.0	
Шууд хамгааллын арга хэмжээ	ТХГ-ын чадавхи менежментийн сайжруулах	Ашиглалтын 1-р жилд		ҮАЗ	
НИЙТ ДҮН				3 000.0	

13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Тухайн жилийн ажлын хүрээнд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг агаар, хөрс, усан орчинд шинжүүлж байхаар хугацаа давтамж зардлыг тооцсон.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
АГААРЫН ЧАНАР						
1.1	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх	Үйлдвэрлэл явагдаж буй талбайд	Үйлдвэр байр болон замын орчимд	Жилд 4 удаа	60000 х жилд 4 удаа х 4цэг х 1 жил НИЙТ 480,000	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ
1.2	Агаарын тоосны шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Нийт үйл ажиллагаанаас орчинд тоосжилт үүсэх, тархах				
1.3	Дуу шуугиан, чичиргээ:	Машин механизмын ажиллагаа хөдөлгөөнөөр шуугиан үүсэх				
ХӨРСНИЙ БОХИРДОЛ						

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
2.1	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс, ялзмагийн агууламж, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Үйлдвэр талбай, овоолго, замын орчимд	жилд 2 удаа	Агрохими 4 цэгт х 2 удаа х 25.0 мян.төг х 1 жил 200.0 Хүнд метал 4 цэгт х 2 удаа х 90.0 мян.төг х 1 жил 720.0 НИЙТ 920,000	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ						

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт байрлах Нүүрс баяжуулах үйлдвэр байгуулах төслийн 2023 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
2.1	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий шинжилгээ					MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
2.2	Усны түвшин усны ундарга, нөөц	Ус ашиглалтаас, зарцуулалтаас газар доорх усны горим өөрчлөгдөх	-Гүний худаг	Жилд 2 удаа	Усны шинжилгээ Ерөнхий 150.0 x 1 цэг x 2 удаа = 300.0 НИЙТ 300,000	
УРГАМЛЫН АЙМАГ						
3.1	Ургамал устгах, өсөлт ургалт нь саагах, төрөл зүйл өөрчлөгдөх, бүрхэц, биомасс багасах	Ургамлын төрөл зүйл, бүрхэц, биомасс, дундаж өндөр, ховор, нэн ховор ургамал	Төсөл хэрэгжиж буй талбай болон түүний ойр орчим 2 цэгт	Жилд 1 удаа	НИЙТ 500,000	ШУА Ботаникийн хүрээлэнтэй хамтарч ажиллах
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН					2,120.0	

13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв /мян.төг/	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаал
1	Сургалт	0.5	0.5	ХАБЭА, БО ажилтан
Нийт дүн сая.төг			0.5	

14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр БОМТ -ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн терийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ.

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах,	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Сум, багийн ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний	11-р сар	Нутгийн иргэдийн саналыг	-
БОАЖЯ-ны ХБОБНУГ-г	Тухайн жилийн	Тайланг хүлээн авсан актыг	12-р сар	-	-

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

Д/д	Хөрөнгийн зориулалт	Хэмжих нэгж	2023 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө /хөрс, ус, агаар, ургамал, ан амьтан/	төг	4 450 000
2	Нөхөн сэргээлт, хаалтын ажлын зардал	төг	4 000 000
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	төг	3 000 000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	төг	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	төг	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	төг	1 100 000
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв	төг	1 600 000
8	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	төг	2 120 000
9	БОМТ -г орон нутагт тайлагнах	төг	-
	Тухайн жилийн байгуулах орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	төг	500 000
	Дүн	төг	16 770 000